



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 05 дугаар сарын 16 өдөр

Дугаар 15

Хэрлэн сум

ХV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 15 дугаар хуралдаан 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 10:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 75,2 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын орлогч дарга Ш.Ёл даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Мал, амьтны сэг зэм устгалыг ажлын талаар мэдээлэл танилцуулах,
Мал эмнэлгийн газар
2. Мал, амьтны сэг зэм тэдгээрийн гаралтай хог хаягдлыг цуглуулж устгах халдвартгүйтгэх арга хэмжээг эрчимжүүлэх хөрөнгө гаргах тухай аймгийн Засаг даргын захирамжийн төсөл танилцуулах,
Мал эмнэлгийн газар
3. Мал, амьтны сэг зэм тэдгээрийн гаралтай хог хаягдлыг цуглуулж устгах халдвартгүйтгэх ажлын хэсэг байгуулах тухай аймгийн Засаг даргын захирамжийн төсөл танилцуулах,
Мал эмнэлгийн газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
 гишүүн Ч.Аюушмаа-д:

1.1. Өвөлжилт хүндэрсэн Баянтүмэн, Булган, Гурванзагал, Сэргэлэн, Хэрлэн, Хөлөнбуйр, Чойбалсан сумдын сэг зэм устгалын ажилд дэмжлэг үзүүлэх талаар тооцож, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэр гаргуулах,

1.2. Мал, амьтны сэг зэм тэдгээрийн гаралтай хог хаягдлыг цуглуулж устгах халдвартгүйтгэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын орлогч даргаар ахлуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мал эмнэлгийн газар, "Чойбалсан хөгжил" ОНӨААТҮГ-ын бүрэлдэхүүнтэй байгуулах тухай аймгийн Засаг даргын захирамжийн төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

/ Ш.Ёл
/ х/ч Б.Цогтбаяр

Хоёр.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа-д:

2.1. Мал, амьтны сэг зэм тэдгээрийн гаралтай хог хаягдлыг цуглуулж устгах халдвартгүйтгэх арга хэмжээг эрчимжүүлэх хөрөнгө гаргах тухай аймгийн Засаг даргын захирамжийн төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулахыг тус тус үүрэг болгов.

ОРЛОГЧ ДАРГА

Ш.ЁЛ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХОШУУЧ

Б.ЦОГТБАЯР